



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 794

Улаанбаатар хот

Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд банк
бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний
зохистой харьцаа тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлэх эх үүсвэрийн харьцааг хавсралтад заасны дагуу тооцсугай:


1/Ногоон зээлийн багц нь Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи”-ийн шаардлагыг хангасан байх;

2/Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоо, уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн байх;

3/Санхүүгийн тайланд тогтвортой байдлын болон уур амьсгалын өөрчлөлтийг стандартын дагуу тайлагнасан байх.


2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
794 дүгээр тогтоолын хавсралт



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД
БАНК БУС САНХҮҮГИЙН ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР
ЭХ ҮҮСВЭР ТАТАХ ХУВЬ ХЭМЖЭЭ

Нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн багцын хувь хэмжээ	Итгэлцлийн үйлчилгээний өглөгийн өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа
2-3 хувь	85%
3-4 хувь	90%
4-5 хувь	95%
5-аас дээш хувь	100%